

ТАНИЛЦУУЛГА

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай
хуулийн төсөл, төслийн үзэл баримтлал

Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Сүүлийн үед технологийн дэвшилүүд ар араасаа гарч хурдацтай хөгжин зах зээлд шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх нь санхүүгийн инноваци болон үр ашигтай байдлыг үүсгэж цаашлаад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж буй хэдий ч зарим төрлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нь гэмт хэрэгтэн, террористуудад мөнгө угаах эсвэл өөрсдийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх арга замуудыг бий болгож байдаг. Эдгээр технологийн дэвшилтээ шийдлүүдийн нэг нь виртуал хөрөнгө юм. Виртуал хөрөнгө нь шинэ технологийн үндсэн дээр үүссэн бөгөөд цаашид ч техник, технологийн хөгжлийг дагаад шинээр санхүүгийн үйлчилгээний тоо ихсэж, түүнийг дагаад гарах эрх зүйн зохицуулалтууд нэмэгдэх хандлагатай байна.

Дээрх үндэслэл, шаардлагын хүрээнд ФАТФ-аас гаргасан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартад (ФАТФ-ын 40 зөвлөмж) Зөвлөмж 15-д 2018 оны 10 дугаар сард орсон өөрчлөлтөд тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь “виртуал хөрөнгөд” нэгэн адилаар үйлчлэхээр тогтох, ФАТФ-ын хүлээн зөвшөөрсөн нэр томъёонд “виртуал хөрөнгө” болон “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” нарыг тодорхойлсон.

ФАТФ-ын 15 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлд хөгжингүй орнууд өөрсдийн хууль тогтоомжид холбогдох өөрчлөлтийг оруулж виртуал хөрөнгийн зохицуулалттай болж эхэлсэн. Жишээлбэл Европын холбооноос “Мөнгө угаахтай тэмцэх 5 дахь удирдамж” - (The Fifth Money Laundering Directive - 5AMLD) гаргаснаар гишүүн орнууд өөрсдийн Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулж виртуал хөрөнгийн зохицуулалтыг тусгах шаардлагатай болсон юм.

Хэдийгээр Монгол Улс нь 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт “саарал жагсаалт”-аас гарсан боловч ФАТФ-ын 15 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлж, виртуал хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулсан үндэсний хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээсэн хэвээр байгаа болно.

Виртуал хөрөнгө гэдэг нь дижитал хэлбэрээр арилжих, шилжүүлэх боломжтой бөгөөд төлбөр, тооцоо мөн хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглаж болох үнэ цэнэ бүхий дижитал буюу биет бус хөрөнгө юм. Виртуал хөрөнгөөр үйлчилгээ үзүүлэгч гэдэг нь дараах үйл ажиллагаа явуулдаг хувь хүн болон хуулийн этгээдийг хэлнэ.

1. Виртуал хөрөнгө болон фиат мөнгөний арилжаа;
2. Виртуал хөрөнгө хоорондын арилжаа;
3. Виртуал хөрөнгийн шилжүүлэг;
4. Виртуал хөрөнгө эсвэл түүнд суурилсан санхүүгийн хэрэгслүүдийн удирдлага, хадгаламж;
5. Виртуал хөрөнгийг худалдах, худалдан авахтай холбоотой санхүүгийн үйлчилгээ.

Виртуал хөрөнгөөр санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дараах үндсэн шаардлагуудыг заавал хэрэгжүүлж байх шаардлагатай байдаг. Үүнд:

- Сэжигтэй гүйлгээ, арилжааны тохиолдлыг мэдээлэх;
- Хэрэглэгчээ таньж мэдэх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг тогтмол явуулах зэрэг болно.

Улс орнууд виртуал валют тэр дундаа криптовалютыг санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах хүрээнд зохицуулалтын төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглаж байна.

Монгол Улсын хувьд авч криптовалют нь албан ёсны хууль, эрх зүйн баримт бичгээр зохицуулагддаггүй, төлбөрийн хэрэгсэлд тооцогдохгүй, Үндэсний төлбөрийн системийн хуульд тодорхойлсон цахим мөнгө биш бөгөөд, цахим мөнгөний аль ч шинжийг агуулдаггүй. Өөрөөр хэлбэл цахим мөнгө, криптовалют нь хоёр тусдаа ойлголт.

Блокчэйн технологид сууриссан криптовалютыг Монгол Улсад бараа, үйлчилгээний төлбөрт ашигладаггүй бөгөөд иргэд харин арилжааны хэрэгсэл болгон ашиглаж байна. Монголбанкнаас бүх төрлийн криптовалютыг төлбөрийн хэрэгсэл гэж үздэггүй, үүнд зөвшөөрөл олгодоггүй, үйл ажиллагааг хянан зохицуулдаггүй. Энэ талаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тус бүр 2 удаа олон нийтэд зориулж мэдэгдэл гаргаж байсан. Гэвч, Монгол улсад криптовалютын арилжаа хийдэг хэд хэдэн цахим хуудас, нэг ATM байгаа бөгөөд үүнтэй холбоотой үйлчилгээ нь Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөх төлбөр тооцооны үйлчилгээнд хамаарахгүй, мөн аль нэг байгууллагын хяналт, зохицуулалт дор байдаггүй. Санхүүгийн хэрэглэгч өөрийн сонголтын хүрээнд биткойн арилжааг хийж, цахим хуудсаар криптовалютыг биржийн зарчмаар арилжаалж байна. Энэ нь дуудлага арилжааны зарчим, зах зээлийн зарчим буюу эрэлт нийлүүлэлт, арилжаанд оролцогчдын хариу үйлдэл дээр тулгуурлан явагдаж байгаа.

Эндээс үзэхэд виртуал хөрөнгө эзэмшигч болон үйлчилгээ үзүүлэгч этгээд Монгол Улсад байгаа боловч эрх зүйн зохицуулалтгүй байна. Одоо хүчин төгөлдөр хууль, тогтоомжийг судлахад Иргэний хуульд биет бус хөрөнгийн тухай зохицуулалт байдаг ч виртуал хөрөнгийн нарийвчилсан зохицуулалт байхгүй, мөн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэх харилцааг зохицуулсан, Татварын ерөнхий хуульд цахим хөрөнгөөс татвар авах зохицуулалт байхгүй боловч эдийн бус хөрөнгө буюу биет бус хөрөнгийг зарж борлуулах, түрээслэхээс олсон орлогод татвар ногдуулахаар байгаа.

Авлигын эсрэг хуульд болон Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хөрөнгө орлогын мэдүүлэгт виртуал хөрөнгийг бүртгүүлэх шаардлага тавигдаагүй, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд ийм төрлийн үйлчилгээ үзүүлэгч нь аль байгууллагаас тусгай зөвшөөрөл авах болон зохицуулагч байгууллага нь аль байгууллага байх талаарх зохицуулалт байхгүй байна. Мөн Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд виртуал хөрөнгийн гүйлгээг тусгайлан зохицуулаагүй. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Үй

олноор зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамруулаагүй, санхүүгийн үйлчилгээ хүртэгч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа хийгдэхгүй байна.

Энэ төрлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь өмнө дурдсанчлан тус технологийн шийдлийг буруугаар ашиглаж, үүсэж болох эдийн засгийн хор хөнөөл, учирч болох аюул өндөр байна. Цаашилбал, хариуцлагын тогтолцоогүй, виртуал хөрөнгө эзэмшигч өмч хөрөнгөөрөө хохирох тохиолдолд хэрхэн зохицуулах, төр ямар байдлаар оролцох, маргааныг хэрхэн шийдвэрлэх асуудал тодорхойгүй байна.

Иймд, Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, ФАТФ-аас гаргасан зөвлөмж 15-н хэрэгжилтийг ханган Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэх харилцан үнэлгээнд эрсдэлтэй орны тоонд оруулах эрсдэлээс хамгаалах үүднээс Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг Хууль, тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын гишүүд болон холбогдох төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллагаас саналыг авсан болно.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцаанд оролцогч байгууллагыг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, оролцогдоос ирүүлсэн саналыг харгалzan хуулийн төслийг боловсруулсан.

Түүнчлэн уг хуулийн төсөл, төслийн үзэл баримтлал, холбогдох судалгаа зэргийг Хууль зүйн, дотоод хэргийн яамны цахим хуудсанд 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс хойш байршуулан олон нийтэд танилцуулж, саналыг авч байгаа болно.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Хуулийн төслийн зохицуулах харилцаа, бүтцийн талаар:

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийн зорилтыг виртуал хөрөнгийн тодорхойлолтыг олон улсын стандартад нийцүүлэн тодорхойлж, түүгээр үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага, бүртгэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахаар хуулийн төсөл болон төслийн үзэл баримтлалд тусгасан болно.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл нь дараах зүйлээс бүрдэнэ:

- Хуулийн зорилт,
- Виртуал хөрөнгийн хууль тогтоомж,
- Хуулийн үйлчлэх хүрээ,
- Нэр томъёоны тодорхойлолт,
- Виртуал хөрөнгийн үйлчилгээнд баримтлах зарчим,
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ,

- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага,
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг,
- Виртуал үйлчилгээ үзүүлэх гэрээ,
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналт тавих,

- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, бүртгэлээс хасах,
- Баримтын хадгалалт, хамгаалалт,
- Мэдээллийн нууцлал,
- Улсын тэмдэгтийн хураамж, зохицуулалтын үйлчилгээний хэлс,
- Хамтын ажиллагаа,
- Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага,
- Шилжилтийн үеийн зохицуулалт.

Виртуал хөрөнгийн үйлчилгээний тухай хуулийн төслөөр виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг, тэдгээрт тавигдах нийтлэг болон нэмэлт шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналтын механизмыг бий болгож, тэдгээрийг гүйцэтгэх субъектыг Санхүүгийн зохицуулах хороо байхаар тодорхойлж, түүний эрх үүргийг төсөлд тусгасан.

Түүнчлэн виртуал хөрөнгө, түүнийг зарж борлуулсан, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлснээс олсон орлогоос татвар оногдуулах, харин тухайн үйлчилгээ үзүүлэгчийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн нэгэн адил Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бий болгож, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.

Виртуал хөрөнгийн арилжаа, хадгалалт, түүнд үзүүлэх үйлчилгээ нь өндөр мэдээлэл технологийн програм хангамж дээр явагддаг, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг хянах нь өндөр техник технологи, боловсон хүчний өндөр ур чадвартай хүн байхыг шаардана.

Иймд тухайн мэдээлэл технологийн чиглэлээр мэргэшсэн өндөр ур чадвартай боловсон хүчнийг авч ажиллуулах шаардлагын хүрээнд цалингийн итгэлцүүр, шатлалыг Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтоохоор Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах төслийг боловсруулсан болно.

Дээрх зохицуулалтын хүрээнд хуулийн төсөл батлагдсанаар виртуал хөрөнгөтэй холбоотой эрх зүйн орчин бүрдэхээс гадна ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх, эдийн засгийн эргэлт нэмэгдэх, гаднын хөрөнгө оруулагч нарыг татах, санхүүгийн хэрэглэгч олон төрлийн төлбөрийн хэрэгслийн сонголттой болж зардал багасах, өмчийн эрх зүйн хамгаалалттай болох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл буурах эерэг нөлөөтэй байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, НҮБ-ын тогтоол болон бусад хуультай харшлахгүй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль,

Татварын ерөнхий хууль, Төрийн олон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах төслийг боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР